



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**



**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
MNS 6541:2015**

Салбарын нэр: Хөдөө аж ахуй

**Мэргэжлийн нэр: Ноос, ноолуур боловсруулалтын технологийн
ажилтан**

БОУСА-ийн хөтөлбөрийн индекс:

Монголын мэргэшлийн үндэсний хүрээний түвшин: VI

**УЛААНБААТАР ХОТ
2019 он**

Боловсруулсан багийн гишүүд:

- | | | |
|---|--------------|---|
| 1 | Д.Өнөрхүү | Увс аймаг дахь “Улаангом” Политехник коллеж, Дэд захирал |
| 2 | Д.Батбаяр | ШУТИС, Үйлдвэрлэлийн Технологийн Сургууль, Ахлах багш, доктор PhD |
| 3 | Б.Бурмаа | МСПК, Ноос ноолуур боловсруулалтын мэргэжлийн багш |
| 4 | А.Бямбасүрэн | МСПК, Ноос ноолуур боловсруулалтын мэргэжлийн багш |
| 5 | С.Дэсмаа | МСПК, Ээрмэлийн мэргэжлийн багш |
| 6 | Х.Оюунгэрэл | Орхон аймаг дахь МСҮТ, Ноос ноолуур боловсруулалтын мэргэжлийн багш |
| 7 | С.Бадамцэцэг | “Говь” ХК-ийн Ангилан ялгах албаны чанар шалгагч, |

Хянасан: ХНХЯ болон ноос, ноолуурын салбарын экспертүүдийн төлөөлөл

- | | | |
|---|-------------|---|
| 1 | Д.Адилбиш | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн |
| 2 | Б.Ганбат | Монголын Ноосон Бүтээгдэхүүн Үйлдвэрлэгчдийн Холбооны Тэргүүн |
| 3 | Р.Бавуудорж | “Туяа” ХХК-ийн Захирал |
| 4 | С.Батмөнх | “Хавт шонхор” ХХК-ийн Үйлдвэр хариуцсан дарга |

DACUM чиглүүлэгч:

- | | | |
|---|-----------|--|
| 1 | Д.Өнөрхүү | Увс аймаг дахь “Улаангом” Политехник коллеж, Дэд захирал |
|---|-----------|--|

Зөвлөхүүд:

- | | | |
|---|-------------|---|
| 1 | Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх |
| 2 | Ц.Ганчимэг | АХБ-ны Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ЧССҮ-ний мэргэжилтэн |
| 3 | Г.Батчимэг | ЧССҮ-ний Зөвлөх |

	АГУУЛГА	Хуудас
	Өмнөх үг	4
1	Зорилго	5
2	Хамрах хүрээ	5
3	Норматив ишлэл	5
4	Нэр томъёо, тодорхойлолт	5
5	Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавигдах шаардлага	8
	5.1 Сургалтын агуулга	8
	5.2 Сургалтын хугацаа	48
6	Суралцах хэлбэр	48
7	Сургалтын үнэлгээнд тавигдах шаардлага	48
8	Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан мэргэжлээр элсэгчдэд тавигдах шаардлага	49
9	Багшид тавигдах шаардлага	49
10	Сургалтын орчинд тавигдах шаардлага	49
11	Сургалтын тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн жагсаалт	51
12	Номын сан, мэдээллийн хангамжид тавигдах шаардлага	55
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага	56
14	Стандартад хэрэглэсэн товчилсон үгийн тайлбар	56

ӨМНӨХ ҮГ

Хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжлээр Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлагыг боловсруулав.

Энэхүү “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”-ыг барилгын засал чимэглэлчид болон ажил олгогчид, чадамжид суурилсан сургалт, үнэлгээний олон улсын зөвлөх, үндэсний зөвлөх, салбарын багш нарын төлөөллийг оролцуулан DACUM арга зүйгээр боловсруулсан ажил мэргэжлийн лавлахад үндэслэн ажилбар, үүрэг нэг бүрээр чадамжийн дүн шинжилгээ хийж боловсруулсан болно.

Мэргэжлийн боловсрол, сургалт нь төр, хувийн хэвшлийн бодит түншлэл, шинэ технологи, шилдэг сургалтын арга зүйд тулгуурлан хөгжиж, өндөр ур чадвартай мэргэжилтэй ажилтнууд төрөн гарч, үйлдвэрлэгч, бүтээгч улс болж, хөгжих болтугай.

1. Зорилго

Энэхүү стандартын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагыг хангахуйц, мэргэшлийн түвшний тогтолцоотой уялдсан уян хатан сургалтыг “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжлээр зохион байгуулах мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, орчин, багшийн мэргэшил, үнэлгээнд тавигдах үндсэн шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандартыг “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжлээр мэргэжлийн боловсрол, сургалт эрхлэн явуулж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, нийгмийн түнш, багш, суралцагч, судлаач, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаарх төрийн удирдлага, аргагүй, хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэглэнэ.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад олон улсын болон үндэсний стандарт, баримт бичгийг иш татаж хэрэглэсэн болно. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 3.1** MNS 1-1:2006 Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг
- 3.2** MNS 1-1:2006 Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг
- 3.3** MNS 5742:2007 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага
- 3.4** MNS 5566:2005 Аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
- 3.5** MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- 3.6** MNS 5869:2008 Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ернхий шаардлага
- 3.7** MNS 5869:2008 Оюутны дотуур байрны үйлчилгээ. Ернхий шаардлага
- 3.8** MNS 0033:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хонины ноос. Техникийн шаардлага
- 3.9** MNS 0036:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Тэмээний ноос. Техникийн шаардлага
- 3.10** MNS 0037:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хялгас. Техникийн шаардлага
- 3.11** MNS 0038:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Ямааны ноолуур. Техникийн шаардлага
- 3.12** MNS 0070:2007 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хөөвөр. Техникийн шаардлага
- 3.13** MNS 5251:2008 Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн хаягдал. Сэв хялгас, богино ноолуур. Техникийн шаардлага
- 3.14** MNS 0780:2007 Ноос, ноолуур. Хонины анхан шатны боловсруулалт хийсэн ноос. Техникийн шаардлага
- 3.15** MNS 3683:2007 Ноос, ноолуур. Ямааны боловсруулсан ноолуур. Техникийн шаардлага

- 3.16 MNS 4950:2007 Ноос, ноолуур. Тэмээний боловсруулсан ноос. Техникийн шаардлага
- 3.17 MNS 5248:2007 Ноос, ноолуур. Сарлагийн боловсруулсан хөөвөр (ноолуур). Техникийн шаардлага
- 3.18 MNS 5251:2008 Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн хаягдал. Зумласан ноос. Техникийн шаардлага
- 3.19 MNS 2951:2007 Ноос, ноолуур. Шинжилгээнд дээж авах арга
- 3.20 MNS 1000:2007 Ноос, ноолуур. Бичил дурангаар нарийн тодорхойлох арга
- 3.21 MNS 1027:2007 Ноос, ноолуур. Хаг, хогт хольц тодорхойлох арга
- 3.22 MNS 2949:2008 Ноос, ноолуур. Бүрэлдэхүүн тодорхойлох арга
- 3.23 MNS 3318:2007 Ноос, ноолуур. Ноосон ширхэгтийн эсгийрэлт тодорхойлох арга
- 3.24 MNS 379:2007 Ноос, ноолуур. Тослог тодорхойлох нэрэх арга
- 3.25 MNS 0380:2007 Ноос, ноолуур. Чийглэг тодорхойлох арга
- 3.26 MNS 3913:2007 Ноос, ноолуур. Хялгас агууламж тодорхойлох арга
- 3.27 MNS 3961:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох тоолох арга
- 3.28 MNS 4954:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох графикайн арга
- 3.29 MNS 4537:2007 Ноос, ноолуур. Тослог тодорхойлох шахах арга
- 3.30 MNS 5821:2007 Ноос, ноолуур. Ноос, химийн ширхэгтийн бөх бат тодорхойлох арга
- 3.31 MNS 0215:2007 Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх журам
- 3.32 MNS 5563:2007 Ноос, ноолуур. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага
- 3.33 MNS 0074:2008 Эсгий гутал. Техникийн шаардлага
- 3.34 MNS 0076:2008 Эсгий гутал. Шинжлэх арга
- 3.35 MNS 0296:2008 Эсгий гутал. Техникийн шаардлага
- 3.36 MNS 1096:2008 Гэрийн эсгий. Шинжлэх арга
- 3.37 MNS 2481:2008 Гэрийн эсгий. Техникийн шаардлага
- 3.38 MNS 2481:2008 Ширмэл зулхай. Техникийн шаардлага
- 3.39 MNS 2483:2008 Ширмэл зулхай. Шинжлэх арга
- 3.40 БНБД 21-01-02 Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал
- 3.41 Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- 3.42 MNS 1-1:2006 Монгол Улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг:
- 3.43 YAMAT-08 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
- 3.44 Ажил мэргэжлийн лавлах толь, Улаанбаатар, 2014

4. Нэр томъёо, тодорхойлолт

4.1

албан боловсрол

боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагааг;

4.2

мэргэжил

тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

4.3

мэргэшил

тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг;

4.4

мэргэжлийн боловсрол

тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.5

техникийн боловсрол

техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.6

мэргэжлийн суурь чадвар

нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшлийг;

4.7

мэргэшлийн түвшин

ажилтны эзэмших мэдлэг, чадвар, гүйцэтгэх ажил үүргийн төлөвшил, хариуцлага, хандлагын хүрээг стандартаар тодорхойлсон мэргэшлийн шатлалыг;

4.8

чадамжид суурилсан сургалт

мэргэжлийн боловсрол, сургалтаар ажлын байранд тухайн ажлыг ажил мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэхийн тулд эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох, төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт;

4.9

чадамжид суурилсан үнэлгээ

суралцагч ажил, үүргийг мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлэн зөв, нямбай хийж гүйцэтгэж байгаа эсэхийг чадамжийн нэгжийн хүрээнд боловсруулсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу нотолгоонд суурилан үнэлгээ хийж, баримтжуулах үйл явц;

4.10

чадамж

хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавигдах мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

4.11

чадамжийн нэгж

үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг гүйцэтгэлийн үнэлэмжийн хамгийн бага нэгж бөгөөд ихэвчлэн үр дүнгээр хэмжигддэг. Тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг;

4.12

чадамжийн элемент

чадамжийн нэгжийн дагуу гүйцэтгэх ёстой ажлын гол хэсгүүд буюу ажилбарыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай гол үе шатууд. Элементүүд нь тодорхой ажлыг гүйцэтгэхэд хэрэгцээтэй үйлдлүүдийг тодорхойлдог;

4.13

гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

чадамжийн нэгж болон элементүүдийг тавигдсан стандартын дагуу гүйцэтгэх шалгуур;

4.14

үнэлгээний төлөвлөгөө

зорилтот бүлгийг ямар чадамжийн нэгжийн шалгуур үзүүлэлтийн дагуу хэзээ, хаана, хэрхэн яаж үнэлэхийг төлөвлөсөн баримт бичиг;

4.15

чадамжийн нэгжийн үнэлгээ

тухайн хувь хүн чадамжийн стандартыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд нотлох материал, мэдээлэл цуглуулж холбогдох үнэлэлт, дүгнэлт гаргах үйл явц;

4.16

чадамжийн багц

ажилтан мэргэжлийн дэлгэрэнгүй тодорхойлолтод нийцүүлж, хөдөлмөрийн чиг үүргийн чанартай гүйцэтгэлийг хангахад шаардагдах мэдлэг, чадвар, туршлага харилцааны багц;

4.17

багц цаг

дээд болон мэргэжлийн боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг.

5. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгад тавих шаардлага

5.1 Сургалтын агуулга

- 5.1.1** Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга нь “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжилд хамаарах чадамжийн нэгжүүдээс бүрдэнэ. Чадамжийн нэгжийг “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжлийн ажил мэргэжлийн тодорхойлолтод (лавлах) тусгагдсан мэргэжлийн үүрэг, ажилбаруудад тулгуурлан боловсруулсан болно.
- 5.1.2** Ажил мэргэжлийн үүрэг, ажилбаруудыг DACUM (ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх) аргаар тодорхойлж, ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулсан.
- 5.1.3** Ажил мэргэжлийн дүн шинжилгээнээс “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжлийн чадамжийн нэгжийн жагсаалтыг тодорхойлж гаргасан. Уг чадамжийн нэгжийн жагсаалтад ороогүй “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжлийн ерөнхий суурь хэсэг болон мэргэжлийн үндсэн ойлголт, онолын мэдлэгийг багш сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

А хавсралт: А.1-р маягт

ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Сургалтын агуулга	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
1	Мэргэжлийн суурь	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах	IE 8152-36-01-301
2		Компьютер ашиглах	IE 8152-36-02-301
3		Амьдрах ухааны ур чадвар эзэмших	IE 8152-36-03-301
4		Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэх	IE 8152-36-04-301
5		Нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх	IE 8152-36-06-301
6	Мэргэшүүлэх	Түүхий эдийг хүлээн авах	IE 8152-36-01-401
7		Ноосыг ангилан ялгах	IE 8152-36-02-401
8		Ноолуур, хөөвөр ангилан ялгах	IE 8152-36-03-401
9		Ноос, ноолуур, хөөврийг угаах	IE 8152-36-04-401
10		Хялгас ялгах	IE 8152-36-05-401
11		Ноос, ноолуур, хөөврийг будах	IE 8152-36-06-401
12		Ноос, ноолуур, хөөврийг холих	IE 8152-36-07-401

- 5.1.4** “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” мэргэжил нь Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VI түвшинд хамаарах бөгөөд хамаарах чадамжийн нэгж бүрийг эзэмших шаардлагатай.
- 5.1.5** Энэхүү стандартын А хавсралт: А.1-р маягтад дурьдах шаардлагатай “Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан” Монголын мэргэшлийн үндэсний хүрээний VI түвшинд харгалзуулах чадамжийн нэгжүүд нь 5.1.3-т зааснаар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд нь А хавсралт: А.3-р маягтад заасны дагуу тодорхойлогдоно.
- 5.1.6** Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөшлийн жагсаалтуудыг А хавсралт, А.2-р маягтын дагуу дараах байдлаар боловсруулсан.
- 5.1.7** Чадамжийн нэгж нь чадамжийн элементүүдээс бүрдэнэ. Чадамжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг А хавсралтын А.3-р маягтын дагуу боловсруулсан. (А хавсралтын А.2, А.3-р маягыг нэгтгэн чадамжийн нэгж бүрээр боловсруулсан.)

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
<p>Эзэмшвэл зохих мэдлэг</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ойлголт, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр • Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал • Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалт • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон мэргэжлийн сургалт • Ажлын байрны соёл, 5S зарчим, Кайзен системийн онол • Ажлын бүсийн агаарын орчин, түүнд тавигдах шаардлага • Үйлдвэрлэлийн тоос, агаарын тоосжилт • Үйлдвэрлэлийн гэрэлтүүлэг, түүний ангилал • Үйлдвэрлэлийн доргио, түүнээс хамгаалах арга, хэрэгсэл • Үйлдвэрлэлийн шуугиан, түүнээс хамгаалах арга, хэрэгсэл • Химийн урвалж бодис, уусмал болон угаагч будагч бодисын аюулгүй ажиллагаа • Хамгаалах техник хэрэгсэл • Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжид тавигдах аюулгүй ажиллагааны шаардлага • Өргөх тээвэрлэх машины аюулгүй ажиллагаа • Цех дотор ба дамжлага хооронд хүнд ачаа тээвэрлэх, шилжүүлэх аюулгүйн нөхцөл • Үйлдвэрлэлийн цахилгааны аюулгүй ажиллагаа • Галын аюулгүй ажиллагаа • Гал унтраах хэрэгсэл <p>Эзэмшвэл зохих ур чадвар</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар судлах • Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангиллыг тоочих • Үйлдвэрлэлийн осол, түүний ангиллыг тоочих • Мэргэжлээс шалтгаалсан өвчин, түүний шалтгааныг тоочих • Ажлын хувцасны төрөл, зориулалтыг тоочих • Ажлын байрны эмх цэгц, зохион байгуулалтыг дурьдах • Бичил цаг уурын үндсэн параметр түүнд тавих эрүүл ахуйн шаардлагыг дурьдах • Ажлын байрны ангилалыг тоочих • Үйлдвэрийн тоос, агаарын тоосжилтын талаар дурьдах • Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, тэдгээрийг ангилал, ялгааг дурьдах • Дуу шуугианаас хамгаалах хувийн хэрэгслийн талаар дурьдах

- Доргионоос хамгаалах аргуудын талаар дурьдах
- Угаах, будах уусмал болон химийн бодистой харьцах үеийн аюулгүй ажиллагааг судлах
- Цахилгаан гүйдэл хүний организмд хэрхэн аюул учруулах талаар дурьдах
- Үйлдвэрлэлийн байр, ажлын нөхцөлийн ангилал, хүн цахилгаан гүйдэлд өртөх аюултай нөхцөлийг судлах
- Цахилгаан тоног төхөөрөмж дэх хамгаалалтын арга хэмжээ, цахилгаанаас хамгаалах хэрэгсэл, ангиллыг дурьдах
- Цахилгаанд осолдогчид үзүүлэх анхны тусламжийн талаар дурьдах
- Аюулгүй ажиллагааны тэмдэг, дохиоллын өнгө, ялгааг дурьдах
- Ачааг гараар шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааны талаар дурьдах
- Хийн тээвэр, түүний аюулгүй ажиллагааны талаар дурьдах
- Галын аюулгүй ажиллагааны хууль дүрмийг судлах
- Шатах, тэсрэх бодисын ангилал, галаас урьдчидан сэргийлэх талаар судлах
- Гал унтраах техник хэрэгсэл, тэдгээрийг ашиглах талаар дурьдах
- Галд өртөгсдөд анхны тусламж үзүүлэх талаар судлах

Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил

- Мэргэжилдээ сонирхолтой байх
- Нягт нямбай, цэвэрч
- Идэвхи санаачлагатай
- Хариуцлагатай
- Хувийн зохион байгуулалт сайтай
- Багаар ажиллах чадвартай
- Хөдөлмөрийн хүмүүжилтэй
- Өөрийгөө хөгжүүлэн сайжруулах эрмэлзэлтэй
- Гоо зүйн мэдрэмжтэй байх
- Анхаарал болгоомжтой байх
- Ёс зүйн дүрэм журам баримтлах

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндсэн асуудлыг судлах	ГШҮ 1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар судлах
	ГШҮ 1.2 Хөдөлмөрийн нөхцлийн сөрөг хүчин зүйлсийг судлан хэрэгжүүлэх
	ГШҮ 1.3 Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангиллыг судлах
	ГШҮ 1.4 Үйлдвэрлэлийн осол, түүний ангиллыг судлах, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх
	ГШҮ 1.5 Мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс сэргийлэх
	ГШҮ 1.6 Ажлын хувцасны төрөл, зориулалтыг тоочих, ажлын хувцсыг өмсөх
	ГШҮ 1.7 Ажлын байрны эмх цэгц, ажлын байрыг зөв зохион байгуулах
	ГШҮ 2.1 Бичил цаг уурын үндсэн параметр түүнд тавих эрүүл ахуйн шаардлагыг мөрдөж ажиллах

ЧЭ 2. Хөдөлмөрийн эрүүл ахуйг хангаж ажиллах	ГШҮ 2.2 Ажлын байрны ангилалыг тоочих
	ГШҮ 2.3 Үйлдвэрийн тоос, агаарын тоосжилтоос сэргийлэх
	ГШҮ 2.4 Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг, тэдгээрийг ангилал, ялгааг дурьдах
	ГШҮ 2.5 Дуу чимээ шуугиан хүний бие организмд хэрхэн нөлөө үзүүлэх талаар дурьдах, дуу шуугианаас хамгаалах хувийн хэрэгслийг ашиглах
	ГШҮ 2.6 Доргионы хүний бие организмд үзүүлэх нөлөө, доргионоос хамгаалах хэрэгслийг ашиглах
	ГШҮ 2.7 Угаах, будах уусмал болон химийн бодистой харьцах үеийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах
ЧЭ 3. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах	ГШҮ 3.1 Цахилгаан гүйдэл хүний организмд хэрхэн аюул учруулах талаар дурьдах
	ГШҮ 3.2 Цахилгаан тоног төхөөрөмж дэх хамгаалалтын арга хэмжээ, цахилгаанаас хамгаалах хэрэгслэлийг ашиглах
	ГШҮ 3.3 Цахилгаанд осолдогчид үзүүлэх
	ГШҮ 3.4 Тоног төхөөрөмжийн хийцийн үндсэн элементэд тавих шаардлагуудыг дурьдах
	ГШҮ 3.5 Аюулгүй ажиллагааны тэмдэг, дохиоллын өнгө, ялгааг таних
	ГШҮ 3.6 Ачааг гараар шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах
	ГШҮ 3.7 Хийн тээвэр, түүний аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах
	ГШҮ 3.8 Галын аюулгүй ажиллагааны хууль дүрмийг судлах
	ГШҮ 3.9 Шатах, тэсрэх бодисын ангилал, галаас урьдчилан сэргийлэх
	ГШҮ 3.10 Гал унтраах техник хэрэгсэл, тэдгээрийг ашиглах
ГШҮ 3.10 Галд өртөгсдөд анхны тусламж үзүүлэх	

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI

Чадамжийн нэгж: Компьютер ашиглах

Чадамжийн нэгжийн код:

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

Эзэмшвэл зохих мэдлэг

- Powerpoint програмы ачаалах
- Програмын цонхны ерөнхий бүтэц
- Мастер хуудастай ажиллах аргачлал
- Слайданд текст оруулах
- Текстийг идэвхижүүлэх, тэмдэглэх арга
- Текстийг форматлах, хэлбэржүүлэх аргачлал
- Бэлэн дүрс оруулах
- Бэлэн дүрсийг хэлбэржүүлэх аргачлал
- Хүснэгт оруулах
- Хүснэгтийн хэмжээг өөрчлөх аргачлал
- Хөл толгойн мэдээлэл оруулах арга
- Жагсаалт үүсгэж, хуудас тохируулах арга
- Шилжилтийн хөдөлгөөн оруулах аргачлал
- Хөдөлгөөнт текст, зураг оруулах
- ХАБЭА-н шаардлагыг мөрдөж ажиллах
- Бүдүүвч байгуулах арга
- Бүдүүвчийн элемент ба холбоосыг форматлах аргачлал
- Графиктай ажиллах арга

Эзэмшвэл зохих ур чадвар

- ХАБЭА-н шаардлагыг мөрдөж ажиллах
- Шинээр мастер хуудас нээх, хадгалах
- Слайд ба түүний элементүүдтэй ажиллах
- ХАБЭА-н шаардлагыг мөрдөж ажиллах
- Слайданд текст оруулж, төрөл бүрийн хэлбэрээр форматлах
- Бэлэн дүрс оруулах
- Бэлэн дүрсийг хэлбэржүүлэх, зургийн цомог бэлтгэх
- Слайданд шилжилтийн хөдөлгөөн оруулах
- Хүснэгт оруулж форматлах
- Жагсаалт үүсгэх
- Хуудас тохируулах
- Слайдын шилжилтийн хөдөлгөөн болон текст, зурганд хөдөлгөөн оруулах
- Зохиомжит хөдөлгөөнт зурагтай ажиллах
- ХАБЭА-н шаардлагыг мөрдөж ажиллах
- Бүдүүвч байгуулах
- Бүдүүвчийн дүрс ба хэмжээг өөрчлөх
- Бүдүүвчийн эффектийг өөрчлөх
- График байгуулж, форматлах

Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил

- Нягт нямбай, цэвэрч байх
- Идэвхи санаачлагатай байх
- Хариуцлагатай байх
- Хувийн зохион байгуулалт сайжирах
- Багаар ажиллах чадвараа хөгжүүлэх
- Сэтгэн бодох чадвараа хөгжүүлэх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. PowerPoint програмын тухай ерөнхий ойлголт	ГШҮ 1.1 Powerpoint програмын цонхны бүтцийг судлах
	ГШҮ 1.2 Слайд ба түүний элементүүдийг судлах
	ГШҮ 1.3 Мастер хуудастай ажиллах
	ГШҮ 1.4 Танилцуулга шинээр үүсгэх ба хадгалах
ЧЭ 2. Мастер хуудастай ажиллах	ГШҮ 2.1 Слайданд текст оруулах
	ГШҮ 2.2 Текстийг идэвхижүүлэх, тэмдэглэх
	ГШҮ 2.3 Текстийг засварлах
	ГШҮ 2.4 Текстийг форматлах
	ГШҮ 2.5 Слайданд дүрс оруулах
	ГШҮ 2.6 Дүрсийг форматлах, хэлбэржүүлэх
	ГШҮ 2.7 Зураг ба зургийн цомог бэлтгэх
ЧЭ 3. Хүснэгтэн мэдээлэлтэй ажиллах, хөдөлгөөн оруулах	ГШҮ 3.1 Слайданд шилжилтийн хөдөлгөөн оруулах
	ГШҮ 3.2 Хөдөлгөөнт текст ба дүрс оруулах
	ГШҮ 3.3 Хүснэгт оруулах
	ГШҮ 3.4 Танилцуулганд хөл ба толгойн мэдээлэл оруулах
	ГШҮ 3.5 Жагсаалт үүсгэх хуудас тохируулах
ЧЭ 4. Бүдүүвч ба графиктай ажиллах	ГШҮ 4.1 Бүдүүвч байгуулах
	ГШҮ 4.2 График байгуулах, объектуудыг форматлах
ЧЭ 5. Интернэт орчинд ажиллах	ГШҮ 5.1 Цахим шуудангийн хаяг нээх
	ГШҮ 5.2 E-mail явуулах ба хүлээн авах
	ГШҮ 5.3 Интернэтээс програм, файл татан хөрвүүлэх
	ГШҮ 5.4 Цахим шуудангийн хаягийн нэр ба нууц үгийг солих, сэргээх
	ГШҮ 5.5 Захидалд файл хавсаргаж илгээх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Амьдрах ухааны ур чадвар эзэмших
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Харилцааны тухай үндсэн ойлголт• Харилцааны үүрэг, зорилго• Харилцааны төрөл• Харилцаанд нөлөөлөх хүчин зүйл• Харилцаанаас гарах үр дагаварууд• Харилцааны орон зай• Хэл яриа, биеийн хэл гэж юу болох• Мэдээллийн хэрэгсэл• Зан төлөв• Зан араншин (темперамент)• Авьяас чадвар, түүний онцлог• Саад бэрхшээлийн тухай ойлголт• Өөрийгөө таних арга барил• Өөрийгөө үнэлэх арга• Өөрийн үнэлэмж• Өөрийгөө илэрхийлэх арга, барилууд• Хувь хүний хөгжлийн мөн чанар• Өөрийн хүсэл мөрөөдөл, зорилгыг зөв тодорхойлох алхам• Хувь хүний зохион байгуулалт, цагийн менежмент• Гэр бүл, найз нөхөд, ойр дотны хүмүүсийн харилцаа, түүний нөлөөлөл• Сэтгэлийн хөдөлгөөн, стрессийн тухай ойлголт• Ажил хэргийн соёл, ёс зүйн ойлголт /Хэл ярианы соёл, бичгийн соёл/• Байгууллага, бүлэг, хамт олон, багийн харилцаа• Манлайлал түүний хэв маяг• Удирдлагатай харилцах харьцаа• Ажлын байрны нөхцлийн нөлөө• Зөрчил маргаан, түүнийг шийдвэрлэх арга зам• Хөдөлмөрийн харилцааны ойлголт• Хөдөлмөрийн гэрээ, түүний нөхцөл
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Харилцааны бүх төрлүүдийг хэрэглэх, өөрийгөө илэрхийлэх, бүрэн ойлгуулах чадвартай болох• Харилцаанд нөлөөлөх хүчин зүйлсийг эерэг хандлагаар өрнүүлэх, харилцах• Бусдын харилцааны онцлог байдалд тохируулан харилцах• Өөрийгөө таньж мэдэх, хувь хүний маркетинг, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх эрмэлзэлтэй болох• Мөрөөдөл, зорилгоо тодорхойлох, зохион байгуулах, төлөвлөх хэрэгжүүлэх

- Гэр бүл, найз нөхөд, ойр дотны хүмүүстэй зохистой харилцах
- Стрессээс сэргийлэх
- Ажил хэргийн харилцаанд соёлтой, ёс зүйтэй оролцох
- Байгууллага бүлэг, хамт олонтой зөв харилцах, багаар ажиллах
- Зөрчил маргааныг удирдах, түүнийг шийдвэрлэдэг байх
- Хөдөлмөрийн харилцаанд хариуцлагатай оролцох

Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил

- Мэргэжилдээ сонирхолтой байх
- Харилцааны ур чадвартай байх
- Бусдыг хүндэтгэн ёс зүйтэй харилцах
- Идэвхи санаачлагатай байх
- Хариуцлагатай байх
- Хувийн зохион байгуулалт сайтай байх
- Багаар ажиллах чадвартай байх
- Сэтгэн бодох чадвар сайтай байх
- Материал хэмнэлттэй зарцуулах
- Гоо зүйн мэдрэмжтэй байх
- Бусдад туслах эрмэлзэлтэй байх
- Цагийг үр бүтээлтэй өнгөрөөх
- Цаг баримтлах
- Гоо зүйн мэдрэмжтэй байх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Харилцааны тухай ойлголт	ГШҮ 1.1 Харилцааны төрлүүдийг нэрлэх, харилцаанд нөлөөлөх хүчин зүйлийг тайлбарлах
	ГШҮ 1.2 Харилцааны орон зайг баримжаалах, харилцагчаа зөв таних арга барилд сурах
	ГШҮ 1.3 Өөрийгөө нүүрний хөдөлгөөний хувирал, дуу хоолойн өнгө, дохио зангаа, биеийн байрлал хөдөлгөөнөөр зөв илэрхийлэх
ЧЭ 2. Хувь хүний харилцааны онцлогийг таних	ГШҮ 2.1 Хүний шинж чанаруудыг ялгах, авьяас чадварын онцлогийг тайлбарлах
	ГШҮ 2.2 Саад бэрхшээлийг даван туулах арга зам, зөрчил, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар тайлбарлах
	ГШҮ 2.3 Хувь хүний темпераментийг тодорхойлж, тохируулан харьцах
	ГШҮ 2.4 Өөрийгөө хайрлан хүндлэх, өөрөөрөө бахархах, өөртөө итгэлтэй байх, өөрийгөө мэдрэх
	ГШҮ 2.5 Бусдыг сонсох, түүний эерэг сөрөг талыг тайлбарлах
	ГШҮ 2.6 Өөрийгөө илэрхийлэх аргуудыг тайлбарлах
	ГШҮ 2.7 Өөрийн санаа бодлоо зөв илэрхийлж, өөрийгөө бусдад зөв таниулахын ач тусыг тайлбарлах

	ГШҮ 2.8 Өөрийн хүсэл мөрөөдөл, зорилгыг зөв тодорхойлох алхмуудыг тайлбарлах
	ГШҮ 2.9 Цагийг үр бүтээлтэй ашиглах, хувийн зохион байгуулалтаа сайжруулах
	ГШҮ 2.10 Гэр бүлийн хүмүүсээ хүндлэх, үүрэг хариуцлагаа ухамсарлах
	ГШҮ 2.11 Гэр бүлийн харилцаа, эхнэр нөхрийн үүрэг хариуцлагыг тодорхойлох
	ГШҮ 2.12 Найз нөхдийн харилцаа, үерхэл нөхөрлөл
	ГШҮ 2.13 Баяр хөөрөө хуваалцаж, уур бухимдлаа тэвчихийн ач тусыг тайлбарлах
	ГШҮ 2.14 Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах, стрессээс урьдчилан сэргийлэх аргуудыг нэрлэх
	ГШҮ 2.15 Айдсаа даван туулах аргуудыг тайлбарлах
	ГШҮ 2.16 Мэдээллийн хэрэгслийг харилцаанд зохистой ашиглах
ЧЭ 3. Хамт олон, нийгэмтэй харилцах	ГШҮ 3.1 Товч намтар (CV), өргөдөл бичих, ярилцлагад бэлтгэхэд анхаарах зүйлүүдийг тайлбарлах
	ГШҮ 3.2 Ажлын хүрээн дахь албан бичиг боловсруулах, анкет бөглөхөд анхаарах зүйлийг тайлбарлах
	ГШҮ 3.3 Байгууллага, бүлэг, хамт олон, багаар ажиллах, зөв харилцах зарчим, арга, зүй тогтлыг тайлбарлах
	ГШҮ 3.4 Ажил хөдөлмөрт өөрийгөө бэлтгэх, ажлын байранд дасан зохицоход анхаарах зүйлийг тайлбарлах
	ГШҮ 3.5 Хөдөлмөрийн гэрээ байгуулах, хөдөлмөрийн харилцаан дахь ажилтны эрх, үүргийг тайлбарлах
	ГШҮ 3.6 Үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл шагнал урамшууллын ялгааг тайлбарлах
	ГШҮ 3.7 Тухайн байгууллагын дүрэм журмын талаар ойлголттой болох
	ГШҮ 3.8 Ажилтан, ажлаа гүйцэтгэж байхдаа өөрийн бураагаас болж учруулсан эд хөрөнгийн хохирлыг хэрхэн төлүүлэх талаар тайлбарлах

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Хувь хүний санхүү, бизнес, аж ахуй эрхлэх
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
<p>Эзэмшвэл зохих мэдлэг</p> <ul style="list-style-type: none"> Зах зээлийн харилцааны тухай ойлголт ухагдахуун, зүй тогтол Бизнесийн үйл ажиллагааны талаарх ойлголт, удирдах арга зүй Төсөл гэж юу болох, эдийн засгийн тооцоо хийх аргачлал <p>Эзэмшвэл зохих ур чадвар</p> <ul style="list-style-type: none"> Хэрэглэгч, үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны хамаарлыг тайлбарлах Худалдаа, арилжааны тухай ерөнхий ойлголтыг тайлбарлах, ашиглах Өөрийн мэргэжлийн чиглэлийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах Шинийг эрэлхийлэх, санаачлах, бүтээлч хандлага эзэмших Орлого, зардал, ашиг алдагдал тооцох Өрсөлдөөний төлөв байдлыг судлах Макро эдийн засгийн орчин нөхцлийг үнэлэх Бизнес санаагаа үнэлэх, сонгох Төсөл бичих <p>Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил</p> <ul style="list-style-type: none"> Мэргэжилдээ сонирхолтой байх Нягт нямбай, цэвэрч байх Идэвхи санаачлагатай байх Хариуцлагатай байх Хувийн зохион байгуулалт сайтай байх Багаар ажиллах чадвартай байх Сэтгэн бодох чадвар сайтай байх Материал хэмнэлттэй зарцуулах Гоо зүйн мэдрэмжтэй байх Бусдад туслах эрмэлзэлтэй байх Цагийг үр бүтээлтэй өнгөрөөх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Зах зээлийн эдийн засгийн сонголт хийх	ГШҮ 1.1 Зах зээлийн үйл ажиллагаатай танилцах
	ГШҮ 1.2 Хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг мэдрэх, түүнд тохирсон бараа үйлчилгээ нийлүүлэх
	ГШҮ 1.3 Өрхийн хэрэглээ ба хуримтлал, төсөвлөлт хийх
	ГШҮ 1.4 Өрсөлдөөний төрөл, хэв шинжийг харьцуулан тайлбарлах
	ГШҮ 1.5 Өрсөлдөөний стратеги боловсруулах

	ГШҮ 1.6 Хөдөлмөрийн зах зээлийн үйл ажиллагаатай танилцах
	ГШҮ 1.7 Үйлдвэрлэлийн нөөцийн зах зээл дээр ажиллах
	ГШҮ 1.8 Макро эдийн засгийн үзүүлэлтийн утгыг ойлгон дүгнэх
	ГШҮ 1.9 Төрийн эдийн засгийн бодлогын нөлөөг тооцон ажиллах
ЧЭ 2. Бизнесийг удирдах	ГШҮ 2.1 Маркетингийн үйл ажиллагааны зорилго, ач холбогдлыг таних
	ГШҮ 2.2 Маркетингийн төлөвлөгөө боловсруулах арга зүйг ойлгох
	ГШҮ 2.3 Байгууллагын менежментийн үйл ажиллагаа явуулах
	ГШҮ 2.4 Байгууллагын чиглэл бүрийг нэгтгэн удирдах, зохион байгуулах идэвхжүүлэх
	ГШҮ 2.5 Байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эерэг сөрөг төлвийг удирдах
ЧЭ 3. Бизнесийн үйл ажиллагааг төлөвлөх, хянах	ГШҮ 3.1 Жижиг дунд бизнесийн санааг үнэлэн сонголт хийх
	ГШҮ 3.2 Бизнесийн байгууллага, түүний хуулийн хэлбэрүүдээс сонгох
	ГШҮ 3.3 Санхүүгийн эх үүсвэр төсөвлөлт, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцох
	ГШҮ 3.4 Банк, санхүүгийн байгууллагатай харилцах
	ГШҮ 3.5 Өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлэх
	ГШҮ 3.6 Төсөл бичих, эдийн засаг үр ашгийн тооцоо хийх
	ГШҮ 3.7 Анхан шатны тайлан баланс гаргах

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI	
Чадамжийн нэгж: Нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх	
Чадамжийн нэгжийн код:	
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага	
Эзэмшвэл зохих мэдлэг	
<ul style="list-style-type: none"> • Нэхээсгүй эдлэлийн үйлдвэрлэл, хөгжил, хэтийн төлөв, нэхээсгүй эдлэлийн тухай ойлголт • Нэхээсгүй эдлэлийн ангилал, нэр төрөл • Түүхий эдийн төрөл, шинж чанар • Зулхай бэлтгэх аргууд • Төрөл бүрийн аргаар үйлдвэрлэсэн нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх • Эсгий эдлэлийн нэр төрөл, ангилал, хэрэглээ • Эсгийрэлт, түүний мөн чанар • Уламжлалт аргаар эсгий хийх • Ширмэл ширдэг ширэх, ширмэлийн хээний тухай • Үйлдвэрлэлийн аргаар эсгий үйлдвэрлэх • Барилгын дулаалгын материал үйлдвэрлэх технологи • Эсгий хийхэд хэрэглэгдэх багаж хэрэгсэл • Төрөл бүрийн эсгий эдлэл үйлдвэрлэх 	
Эзэмшвэл зохих ур чадвар	
<ul style="list-style-type: none"> • ХАБЭА-г мөрдөж ажиллах • Түүхий эдийг сонгох • Зулхай бэлтгэх • Төрөл бүрийн аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх • Эсгий хийхэд хэрэглэгдэх багаж хэрэгслийг зөв ашиглах • Уламжлалт аргаар эсгий эдлэл үйлдвэрлэх • Төрөл бүрийн эсгий эдлэлийн хэв, үлгэр гаргах, эсгий эдлэл үйлдвэрлэх 	
Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил	
<ul style="list-style-type: none"> • Мэргэжилдээ сонирхолтой байх • Нягт нямбай, цэвэрч • Идэвхи санаачлагатай • Хариуцлагатай • Хувийн зохион байгуулалт сайтай • Багаар ажиллах чадвартай • Хөдөлмөрийн хүмүүжилтэй • Өөрийгөө хөгжүүлэн сайжруулах эрмэлзэлтэй • Ёс зүйн дүрэм журам баримтлах • Хаягдлын зарцуулалтыг тооцох 	

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
	ГШҮ 1.1 Нэхээсгүй эдлэлийн ангилал, нэр төрлийг судлах

ЧЭ 1. Түүхий эд, зулхай бэлтгэх	ГШҮ 1.2 Түүхий эдийн нэр төрөл, шинж чанарыг судалж, сонгох
	ГШҮ 1.3 Зулхай бэлтгэх
ЧЭ 2. Төрөл бүрийн аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх	ГШҮ 2.1 Сүлжиж оёх аргаар үйлдвэрлэсэн нэхээсгүй эдлэлийн нэр төрөл, шинж чанар, машин тоног төхөөрөмжийн талаар судлах
	ГШҮ 2.2 Физик химийн аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.3 Утас наах аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.4 Өндөр хэмд шахаж нягтруулах аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.5 Нойтон боловсруулалтын аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.6 Шууд хэлбэршилтийн аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.7 Зүүгээр шивэх аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.8 Цахилгаан цэнэгийн аргаар нэхээсгүй эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 2.9 Тафтинг хивс үйлдвэрлэх
ЧЭ 3. Төрөл бүрийн эсгий, эсгий эдлэл үйлдвэрлэх	ГШҮ 3.1 Эсгий хийхэд хэрэглэгдэх багаж хэрэгслийн үүрэг зориулалтыг судлах
	ГШҮ 3.2 Уламжлалт аргаар эсгий эдлэл үйлдвэрлэх
	ГШҮ 3.3 Эсгий эдлэлийн үлгэр бэлтгэх, төрөл бүрийн эсгий эдлэлийн хэв гаргах
	ГШҮ 3.4 Эсгий малгай хийх
	ГШҮ 3.5 Эсгий бойтог хийх
	ГШҮ 3.6 Эсгий тоглоом, наадгай хийх
	ГШҮ 3.7 Эсгий гутал хийх
	ГШҮ 3.8 Ноосон зулмал зураг бүтээх
	ГШҮ 3.9 Эсгийгээр төрөл бүрийн ном, цүнх, бэлэг дурсгалын зүйлс хийх

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Түүхий эд хүлээн авах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг ашиглах арга• Бэлтгэлийн үеийн ХАБЭА-н дүрэм• Шимэгч амьтны хор, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга• Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж• Ямааны ноолуурын үүлдэр, омог, төрөл• Ямааны ноолуурын зэрэг, чанар, өнгө• Хонины ноосны үүлдэр, омог, төрөл• Хонины ноосны зэрэг, чанар, өнгө• Тэмээний ноосны үүлдэр, омог, төрөл• Тэмээний ноосны зэрэг, чанар, өнгө• Сарлагийн хөөврийн үүлдэр, омог, төрөл• Сарлагийн хөөврийн зэрэг, чанар, өнгө• Хөвөн, олсон ширхэгтийн төрөл, сорт• Хөвөн, олсон ширхэгтийн зэрэг, чанар• Ангор ямааны ноос, лама гөрөөс, туулайн ноолуурын төрөл• Ангор ямааны ноос, лама гөрөөс, туулайн ноолуурын зэрэг, чанар• Химийн гаралтай ширхэгт материалыг таних энгийн арга• Химийн ширхэгт материалыг таних шатаах арга
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг зөв өмсөх• Бэлтгэлийн үеийн ХАБЭА-н дүрмийг мөрдөх• Шимэгч амьтны хор, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх• Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж үзүүлэх• Ямааны ноолуурыг үүлдэр, омог, ноолуурын төрлөөр нь ялгаж хүлээн авах• Ямааны ноолуурыг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах• Хонины ноосыг үүлдэр, омог, ноосны төрлөөр нь ялгаж хүлээн авах• Хонины ноосыг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах• Тэмээний ноосыг үүлдэр, омог, ноосны төрлөөр нь ялгаж хүлээн авах• Тэмээний ноосыг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах• Сарлагийн хөөврийг үүлдэр, омог, хөөврийн төрлөөр нь ялгаж хүлээн авах• Сарлагийн хөөврийг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах• Хөвөн, олсон ширхэгтийг төрөл, сортоор нь ялгаж хүлээн авах• Хөвөн, олсон ширхэгтийг зэрэг, чанараар нь ялгаж хүлээн авах• Ангор ямааны ноос, лама гөрөөс, туулайн ноолуурыг төрлөөр нь ялгаж хүлээн авах• Ангор ямааны ноос, лама гөрөөс, туулайн ноолуурыг зэрэг, чанараар нь ялгаж хүлээн авах

- Химийн гаралтай ширхэгт материалыг энгийн аргаар таних
- Химийн ширхэгт материалыг шатаах аргаар таних

Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил

- Мэргэжилдээ сонирхолтой байх
- Нягт нямбай, цэвэрч
- Идэвхи санаачлагатай
- Хариуцлагатай
- Хувийн зохион байгуулалт сайтай
- Багаар ажиллах чадвартай
- Хөдөлмөрийн хүмүүжилтэй
- Өөрийгөө хөгжүүлэн сайжруулах эрмэлзэлтэй
- Ёс зүйн дүрэм журам баримтлах
- Гоо зүйн мэдрэмжтэй байх
- Анхаарал болгоомжтой байх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ЧЭ 1. Бэлтгэлийн үеийн ХАБЭА-г хангах	ГШҮ 1.1 Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /малгай, маск, ханцуйвч, хормогч, ажлын гутал/-ийг өмсөх
	ГШҮ 1.2 Бэлтгэлийн үеийн ХАБЭА-н дүрмийг мөрдөх
	ГШҮ 1.3 Шимэгч амьтны хор, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх
	ГШҮ 1.4 Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж үзүүлэх
ЧЭ 2. Ямааны ноолуур хүлээн авах	ГШҮ 2.1 Ямааны ноолуурыг үүлдэр, омог, ноолуурын төрлөөр нь ялгаж хүлээн авах
	ГШҮ 2.2 Ямааны ноолуурыг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах
ЧЭ 3. Хонины ноос хүлээн авах	ГШҮ 3.1 Хонины ноосыг үүлдэр, омог, ноосны төрлөөр нь ялгаж хүлээн авах
	ГШҮ 3.2 Хонины ноосыг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах
ЧЭ 4. Тэмээний ноос хүлээн авах	ГШҮ 4.1 Тэмээний ноосыг үүлдэр, омог, ноосны төрлөөр нь ялгаж хүлээн авах
	ГШҮ 4.2 Тэмээний ноосыг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах
ЧЭ 5. Сарлагийн хөөвөр хүлээн авах	ГШҮ 5.1 Сарлагийн хөөврийг үүлдэр, омог, хөөврийн төрлөөр нь ялгаж хүлээн авах
	ГШҮ 5.2 Сарлагийн хөөврийг зэрэг, чанар, өнгөөр нь ялгаж хүлээн авах
ЧЭ 6. Ургамлын гаралтай	ГШҮ 6.1 Хөвөн, олсон ширхэгтийг төрөл, сортоор нь ялгаж хүлээн авах

ширхэгтийг таних	ГШҮ 6.2 Хөвөн, олсон ширхэгтийг зэрэг, чанараар нь ялгаж хүлээн авах
ЧЭ 7. Онцлог ширхэгтийг таних	ГШҮ 7.1 Ангор ямааны ноос, лама гөрөөс, туулайн ноолуурыг төрлөөр нь ялгаж хүлээн авах
	ГШҮ 7.2 Ангор ямааны ноос, лама гөрөөс, туулайн ноолуурыг зэрэг, чанараар нь ялгаж хүлээн авах
ЧЭ 8. Химийн ширхэгтийг таних	ГШҮ 8.1 Химийн гаралтай ширхэгт материалыг энгийн аргаар таних
	ГШҮ 8.2 Химийн ширхэгт материалыг шатаах аргаар таних

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Ноосыг ангилан ялгах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /малгай, маск, ханцуйвч, хормогч, ажлын гутал/-ийн зориулалт• Ангилан ялгах үеийн ХАБЭА-н дүрэм• Шимэгч амьтны хор, хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх арга• Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж• Ноос, ноолуур ялгах ажлын байрны стандарт• Ноос, ноолуур ялгах ажлын байрны эмх цэгц• Ноос ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалт• Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан ноос хийх авдар• Авдрыг ноосны зэрэг, чанараар нь хаягжуулах тухай• Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнс• Ноосны бэлтгэлийн “MNS Улсын стандарт”• Ноосны бэлтгэлийн “Байгууллагын стандарт”• Ноосны ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүй• Хонины ноосны геометр шинж чанар• Ноосны техникийн шинж чанар• Хонины нарийн ноосны чанар, зэрэг• Хонины нарийвтар ноосны чанар, зэрэг• Хонины бүдүүн ноосны өнгө, чанар, зэрэг• Хонины бүдүүвтэр ноосны өнгө, чанар, зэрэг• Тэмээний ноосны бэлтгэлийн “MNS Улсын стандарт”• Тэмээний ноосны бэлтгэлийн “Байгууллагын стандарт”• Тэмээний ноосны ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүй• Тэмээний ноосны геометр шинж чанар• Тэмээний ноосны техникийн шинж чанар• Тэмээний ноосны насны онцлог• Тэмээний ноосны бүтэц, чанар• Тэмээний ноосны өнгө• Тэмээний ноосны гадаад байдал, бохирдолт• Пресслэх машины бүтэц, ажиллах зарчим• Пресслэх машины ажлын эд ангиуд• Пресслэх ноосыг бэлтгэхэд шаардлагатай зүйл• Пресслэсэн ноосыг жигнэлт, хаягжуулалт
Эзэмшвэл зохих ур чадвар <ul style="list-style-type: none">• Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /малгай, маск, ханцуйвч, хормогч, ажлын гутал/-ийг өмсөх• Ангилан ялгах үеийн ХАБЭА-н дүрмийг мөрдөх• Шимэгч амьтны хор, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх• Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж үзүүлэх

- Ноос, ноолуур ялгах ажлын байрны стандартыг судалж мөрдөх
- Ноос, ноолуур ялгах ажлын байрыг эмхэлж цэгцлэх
- Ноос ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалтыг судлах
- Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан ноос хийх авдрыг зөв байрлуулах
- Авдрыг ноосны зэрэг, чанараар нь хаягжуулж дугаарлах
- Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнсийг ажиллуулах
- Ноосны бэлтгэлийн “MNS Улсын стандарт”-ыг судлах
- Ноосны бэлтгэлийн “Байгууллагын стандарт”-ыг судлах
- Ноосны ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүйг тодорхойлох
- Хонины ноосны геометр шинж чанарыг тодорхойлох
- Ноосны техникийн шинж чанарыг тодорхойлох
- Хонины нарийн ноосыг чанар, зэргээр нь ангилан ялгах
- Хонины нарийвтар ноосыг чанар, зэргээр нь ангилан ялгах
- Хонины бүдүүн ноосыг өнгө, чанар, зэргээр нь ангилан ялгах
- Хонины бүдүүвтэр ноосыг өнгө, чанар, зэргээр нь ангилан ялгах
- Тэмээний ноосны бэлтгэлийн “MNS Улсын стандарт”-ыг судлах
- Тэмээний ноосны бэлтгэлийн “Байгууллагын стандарт”-ыг судлах
- Тэмээний ноосны ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүйг тодорхойлох
- Тэмээний ноосны геометр шинж чанарыг тодорхойлох
- Тэмээний ноосны техникийн шинж чанарыг тодорхойлох
- Тэмээний ноосыг насны онцлогоор нь ялгах
- Тэмээний ноосны бүтэц, чанараар нь ангилан ялгах
- Тэмээний ноосыг өнгөөр нь ангилан ялгах
- Тэмээний ноосыг гадаад байдал, бохирдолтоор нь ялгах
- Пресслэх машины бүтэц, ажиллах зарчмыг судлах
- Пресслэх машиныг ажилд бэлтгэж ажлын эд ангиудын бүрэн бүтэн байдлыг шалгах
- Пресслэх ноосыг бэлтгэх
- Пресслэх машиныг ажиллуулах
- Пресслэсэн ноосыг жигнэж, хаягжуулах

Хөдөлмөр эрхлэхэд зайлшгүй шаардлагатай хандлага, төлөвшил

- Мэргэжилдээ сонирхолтой байх
- Нягт нямбай, цэвэрч
- Идэвхи санаачлагатай
- Хариуцлагатай
- Хувийн зохион байгуулалт сайтай
- Багаар ажиллах чадвартай
- Хөдөлмөрийн хүмүүжилтэй
- Өөрийгөө хөгжүүлэн сайжруулах эрмэлзэлтэй
- Ёс зүйн дүрэм журам баримтлах
- Анхаарал болгоомжтой байх
- Гоо зүйн мэдрэмжтэй байх

Элемент, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

ЭЛЕМЕНТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
---------	-------------------------------

ЧЭ 1. Ноос ангилан ялгах үеийн ХАБЭА-г хангах	ГШҮ 1.1 Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /малгай, маск, ханцуйвч, хормогч, ажлын гутал/-ийг өмсөх
	ГШҮ 1.2 Ангилан ялгах үеийн ХАБЭА-н дүрмийг мөрдөх
	ГШҮ 1.3 Шимэгч амьтны хор, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх
	ГШҮ 1.4 Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж үзүүлэх
ЧЭ 2. Ноос ялгах ажлын байр, ялгах хэрэгслийг бэлтгэх	ГШҮ 2.1 Ноос, ноолуур ялгах ажлын байрны стандартыг судалж мөрдөх
	ГШҮ 2.2 Ноос, ноолуур ялгах ажлын байрыг эмхэлж цэгцлэх
	ГШҮ 2.3 Ноос ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалтыг судлах
	ГШҮ 2.4 Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан ноос хийх авдрыг зөв байрлуулах
	ГШҮ 2.5 Авдрыг ноосны зэрэг, чанараар нь хаягжуулж дугаарлах
	ГШҮ 2.6 Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнсийг ажиллуулах
ЧЭ 3. Ноосны түүхий эд бэлтгэлийн стандартыг судлах	ГШҮ 3.1 Ноосны бэлтгэлийн “MNS Улсын стандарт”-ыг судлах
	ГШҮ 3.2 Ноосны бэлтгэлийн “Байгууллагын стандарт”-ыг судлах
ЧЭ 4. Ноосны шинж чанарыг тодорхойлох	ГШҮ 4.1 Ноосны ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүйг тодорхойлох
	ГШҮ 4.2 Хонины ноосны геометр шинж чанарыг тодорхойлох
	ГШҮ 4.3 Ноосны техникийн шинж чанарыг тодорхойлох
ЧЭ 5. Нарийн, нарийвтар ноос ялгах	ГШҮ 5.1 Хонины нарийн ноосыг чанар, зэргээр нь ангилан ялгах
	ГШҮ 5.2 Хонины нарийвтар ноосыг чанар, зэргээр нь ангилан ялгах
ЧЭ 6. Бүдүүн, бүдүүвтэр ноос ялгах	ГШҮ 6.1 Цаасан өнгөлгөө наах гадаргууг цавуудах
	ГШҮ 6.2 Цаасан өнгөлгөөг гадаргууд нааж эхлэх
	ГШҮ 6.3 Цаасан өнгөлгөөний наалтыг эцэслэх
	ГШҮ 6.4 Цаасны дээд ирмэгийг зүсэх
	ГШҮ 6.5 Цаасан өнгөлгөөний наалтыг шалгах
	ГШҮ 6.6 Ажлын байрыг цэвэрлэх
ЧЭ 7. Тэмээний ноосны бэлтгэлийн стандартыг судлах	ГШҮ 7.1 Тэмээний ноосны бэлтгэлийн “MNS Улсын стандарт”-ыг судлах
	ГШҮ 7.2 Тэмээний ноосны бэлтгэлийн “Байгууллагын стандарт”-ыг судлах

ЧЭ 8. Тэмээний ноосны шинж чанарыг тодорхойлох	ГШҮ 8.1 Тэмээний ноосны ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүйг тодорхойлох
	ГШҮ 8.2 Тэмээний ноосны геометр шинж чанарыг тодорхойлох
	ГШҮ 8.3 Тэмээний ноосны техникийн шинж чанарыг тодорхойлох
ЧЭ 9. Тэмээний ноос ялгах	ГШҮ 9.1 Тэмээний ноосыг насны онцлогоор нь ялгах
	ГШҮ 9.2 Тэмээний ноосны бүтэц, чанараар нь ангилан ялгах
	ГШҮ 9.3 Тэмээний ноосыг өнгөөр нь ангилан ялгах
	ГШҮ 9.4 Тэмээний ноосыг гадаад байдал, бохирдлоор нь ялгах
ЧЭ 10. Ноосыг пресслэх	ГШҮ 10.1 Пресслэх машины бүтэц, ажиллах зарчмыг судлах
	ГШҮ 10.2 Пресслэх машиныг ажилд бэлтгэж ажлын эд ангиудын бүрэн бүтэн байдлыг шалгах
	ГШҮ 10.3 Пресслэх ноосыг бэлтгэх
	ГШҮ 10.4 Пресслэх машиныг ажиллуулах
	ГШҮ 10.5 Пресслэсэн ноосыг жигнэж, хаягжуулах

Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага

ТҮВШИН VI
Чадамжийн нэгж: Ноолуур, хөөвөр ангилан ялгах
Чадамжийн нэгжийн код:
Чадамжийн нэгжийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага
Эзэмшвэл зохих мэдлэг <ul style="list-style-type: none">• Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /малгай, маск, ханцуйвч, хормогч, ажлын гутал/• Ангилан ялгах үеийн ХАБЭА-н дүрэм• Шимэгч амьтны хор, хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх арга• Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж• Ноолуур ялгах ажлын байрны стандарт• Ноолуур ялгах ажлын байрыг эмхэлж цэгц• Ноолуур ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалт• Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан ноолуур хийх сагсны хэрэглээ• Сагсыг ноолуурын зэрэг, чанараар нь хаягжуулалт• Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнс• Ноолуурын бэлтгэлийн “MNS Улсын стандарт”• Ноолуурын бэлтгэлийн “Байгууллагын стандарт”• Ноолууран ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүй• Ямааны ноолуурын геометр шинж чанар• Ноолуурын техникийн шинж чанар• Ноолуурын нарийн бүдүүн /голч/• Ноолуурын чанар• Ноолуурын өнгө• Ноолуурын гадаад байдал төрөл• Сарлагийн хөөвөр ялгах ажлын байрны стандарт• Хөөвөр ялгах ажлын байрыг эмх цэгц• Хөөвөр ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалт• Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан хөөвөр хийх сагсыг зөв байрлуулалт• Сагсны хаягжуулалт• Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнс• Сарлагийн хөөврийн бэлтгэлийн “MNS Улсын стандарт”• Сарлагийн хөөврийн бэлтгэлийн “Байгууллагын стандарт”• Сарлагийн хөөврийн гадаад бүтэц, хэлбэр зүй• Сарлагийн хөөврийн геометр шинж чанар• Сарлагийн хөөврийн техникийн шинж чанар• Хөөврийн нарийн бүдүүн /голч/• Хөөврийн чанар• Хөөврийн өнгө• Хөөврийн гадаад байдал төрөл• Пресслэх машины ажлын эд ангиуд• Пресслэх ноолуур, хөөврийг бэлтгэх арга технологи• Пресслэсэн ноолуур, хөөврийг жигнэлт, хаягжуулалт

Эзэмшвэл зохих ур чадвар

- Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл /малгай, маск, ханцуйвч, хормогч, ажлын гутал/-ийг өмсөх
- Ангилан ялгах үеийн ХАБЭА-н дүрмийг мөрдөх
- Шимэгч амьтны хор, хөнөөлөөс урьдчилан сэргийлэх
- Шимэгч амьтны хор хөнөөлд өртсөн үед анхан шатны тусламж үзүүлэх
- Ноолуур ялгах ажлын байрны стандартыг судалж мөрдөх
- Ноолуур ялгах ажлын байрыг эмхэлж цэгцлэх
- Ноолуур ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалтыг судлах
- Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан ноолуур хийх сагсыг зөв байрлуулах
- Сагсыг ноолуурын зэрэг, чанараар нь хаягжуулж дугаарлах
- Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнсийг ажиллуулах
- Ноолуурын бэлтгэлийн “MNS Улсын стандарт”-ыг судлах
- Ноолуурын бэлтгэлийн “Байгууллагын стандарт”-ыг судлах
- Ноолууран ширхэгтийн гадаад бүтэц, хэлбэр зүйг тодорхойлох
- Ямааны ноолуурын геометр шинж чанарыг тодорхойлох
- Ноолуурын техникийн шинж чанарыг тодорхойлох
- Ноолуурыг нарийн бүдүүнээр /голч/ нь зэрэглэх
- Ноолуурыг чанараар нь зэрэглэх
- Ноолуурыг өнгөөр нь ангилан ялгах
- Ноолуурыг гадаад байдал төрлөөр нь ангилах
- Сарлагийн хөөвөр ялгах ажлын байрны стандартыг судалж мөрдөх
- Хөөвөр ялгах ажлын байрыг эмхэлж цэгцлэх
- Хөөвөр ялгах хэрэгслийн нэр төрөл, бүтэц онцлог, ашиглалтыг судлах
- Ажлын багаж, хэрэгсэл, ялгасан хөөвөр хийх сагсыг зөв байрлуулах
- Сагсыг хөөврийн зэрэг, чанараар нь хаягжуулж дугаарлах
- Ажлын ширээний тоос, хогт хольцыг сорох сэнсийг ажиллуулах
- Сарлагийн хөөврийн бэлтгэлийн “MNS Улсын стандарт”-ыг судлах
- Сарлагийн хөөврийн бэлтгэлийн “Байгууллагын стандарт”-ыг судлах
- Сарлагийн хөөврийн гадаад бүтэц, хэлбэр зүйг тодорхойлох
